



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХХVII ХУРЛЫН ТОГТООЛ

2020.04.30

№ 02

Улаанбаатар

Өөрийн хувьцааг худалдан авахыг зөвшөөрөх тухай:

Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, 49 дүгээр зүйлийн 49.10 дахь заалт, 62 дүгээр зүйлийн 62.1.12 дахь заалт, Би Ди Сек Үнэт цаасны хувьцаат компаниас ирүүлсэн санал, тооллогын комиссын 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Тогтоох нь:

1. Компанийн нийт гаргасан хувьцаанаас 25000 хүртэл тооны хувьцааг худалдан авахыг зөвшөөрч, энэ асуудлаар шийдвэр гаргах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
2. Хэлцэл хийсэн тохиолдолд Компанийн болон МХБ-ийн цахим хуудсанд мэдээлэл байршуулах замаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Аюуш)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.АЮУШ



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХХVII ХУРЛЫН ТОГТООЛ

2020.04.30

№ 01

Улаанбаатар

Дүгнэлт төсөв батлах тухай:

Компанийн тухай хуулийн 62.1.9 болон 62.1.13 дах заалт, ТУЗ-ийн дүгнэлт, хувьцаа эзэмшигчдийн ХХVI хурлын Тооллогын комиссын 2 дугаар тогтоолыг үндэслэн Тогтоох нь:

1. Компанийн 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн ТУЗ-ийн 2020 оны зардлыг хавсралтаар баталсугай.

ДАРГА



Б.АЮУШ



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХХVII ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2020 оны 04 дүгээр сарын
30-ны өдөр

Дугаар.01

Улаанбаатар хот

Хурал хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 69.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7.4 дэх заалт, Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналын хуудсын бүртгэсэн дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Баянгол Зочид Буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ХХVII-р хуралд 381,133 ш хувьцааг эзэмшсэн 1115 хувь нийлүүлэгчдээс 306,895 ш хувьцаа эзэмшдэг 54 хувь нийлүүлэгч саналаа ирүүлсэн нь нийт саналын эрхтэй хувьцааны 80,5 хувь болсон тул санал хураалт хүчин төгөлдөр болох ирц хүрснийг мэдэгдсүгэй.

КОМИССЫН ДАРГА



Д.САМДАНЖАМЦ



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХХVII ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2020 оны 04 дүгээр сарын
30-ны өдөр

Дугаар..02

Улаанбаатар хот

Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9, 63.5 болон 67.3.8 дах заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах асуудлаар нийт өгсөн саналын тоо 306,895 үүнээс татгалзсан 0 түдгэлзсэн 0, зөвшөөрсөн 306,895 нийт ирүүлсэн саналын эрхийн 100 хувийн саналаар уг шийдвэр хүчин төгөлдөр болсон
2. Компанийн ТУЗ-ын зардлын төсвийг батлах асуудлаар нийт өгсөн саналын тоо 306,895 үүнээс татгалзсан 0 түдгэлзсэн 0, зөвшөөрсөн 309,895 нийт ирүүлсэн саналын эрхийн 100 хувийн саналаар уг шийдвэр хүчин төгөлдөр болсон
3. Компанийн энгийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг зөвшөөрөх асуудлаар нийт өгсөн саналын тоо 306,895, үүнээс татгалзсан 191 түдгэлзсэн 0, зөвшөөрсөн 306,704 хувийн нийт ирүүлсэн саналын эрхийн 99,99 хувийн саналаар уг шийдвэр хүчин төгөлдөр болсоныг мэдэгдсүгэй.

КОМИССЫН ДАРГА



Д.САМДАНЖАМЦ